



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 8/35

Мандалговь

“Бодь электроникс” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйл 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн А/27 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Цахим төр-Ухаалаг Дундговь”-ийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Бодь электроникс” ХХК-тай 84,615,300 (наян дөрвөн сая зургаан зуун арван таван мянга гурван зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн нөхцөлийн дагуу чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Бодь электроникс” ХХК-ний захирал (Х.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Н.Түвшинжаргал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

4822150195